

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД 2019 ОНД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СУДЛАХ СУДАЛГААНЫ АЖИЛ

О.АЛТАНТУЯА

МҮИС-ИЙН ХЭС-ИЙН НИЙТИЙН ЗРХ ЗҮЙН ТЭНХИМИЙН БАГШ

Д.БАДАМДАШ

МҮИС-ИЙН ШУС-ИЙН УЛС ТӨР СУДЛАЛЫН ТЭНХИМИЙН БАГШ

МҮИС-ИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ, ШУС-ИЙН УЛС ТӨРИЙН
ТЭНХИМИЙН ОЮУТНУУД ХАМТРАН БҮТЭЭВ.

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ
2021 ОН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

© Энэхүү бүтээлийг америкийн ард түмний дэмжлэгээс бүрдсэн АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтай, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд бүтээв.

Бүтээлд илэрхийлэгдсэн үзэл санаанууд нь уг бүтээлийн зохиогчдын үзэл санаа бөгөөд АНУ-ын Засгийн газар, эсхүл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД 2019 ОНД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СУДЛАХ СУДАЛГААНЫ АЖИЛ

*Монгол Улсын 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт,
өөрчлөлтийг судлах судалгааны төслийн тухай*

Монгол Улс түүхэндээ дөрвөн Үндсэн хууль баталсны дөрөв дэх нь 1992 оны ардчилсан, шинэ тодотголтой одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Үндсэн хууль билээ. Үндсэн хууль нь нийгмийн амьдралын бүхий л хүрээний суурь харилцааг зохицуулдаг улс төр, эрх зүйн баримт бичиг учраас тогтвортой үйлчлэх шинжийг агуулж байх учиртай ч нийгмийн хөгжил, хэрэгцээ шаардлагын дагуу зайлшгүй, шаардлагатай, зохих нэмэлт, өөрчлөлтүүд орж байх нь зүйн хэрэг юм. Өдгөө 30 жилийн түүхтэй тус Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал олон удаа хөндөгдсөн боловч 1999 (2000) болон 2019 онд нийт хоёр удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. 1999 (2000) оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар судалсан судалгааны ажлууд нэлээд байдаг бол 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь төдийлөн судлагдаагүй бөгөөд хэрэгжилтийн байдал хангалтгүй байна.

Судалгааны баг Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, эх бичвэр, онолын ойлголтыг удирдлага болгон 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, ач холбогдол, хэрэгцээ шаардлага, нийцүүлэн гарсан эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийх, гадаад орнуудын холбогдох эрх зүйн зохицуулалтыг харьцуулах, нэмэлт, өөрчлөлттэй холбогдох бусад үйл явцыг судлахад гол анхаарал хандуулав.

Монгол Улсын Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хангах нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалтай холбоотой бөгөөд аливаа нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцсэн байх шаардлагатай байдаг. Үндсэн хуулийн эхийг баригч, эрдэмтэн Б.Чимид “Үндсэн хууль бол Монгол эх орны төлөө, Монгол Улсын иргэн бидний төлөө, засаг төрийн дур зоргыг хязгаарласан шударга ёсны төлөө, үндэсний эв нэгдлийн төлөө, Монголын ард түмний нийтлэг хүсэл зоригийг илэрхийлсэн, улсын гол хууль мөн” хэмээн нэгэнтээ тодорхойлжээ. Үндсэн хууль нь ийнхүү “улсын гол хууль” учраас түүний суурь үзэл баримтлал, зүйл заалт, түүнд холбогдох нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн улс төр, хуулийн хүрээллийнхний анхаарлын төвд байх асуудал биш гэдэгт судалгааны багийн гишүүд санал нэгдэж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг олон нийтийн анхаарлын төвд хүргэх, иргэдийн бүрэн эрхт байдал, оролцоог нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлэх, Үндсэн хуульд байгууллыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилго өвөртлөв. Иймд Үндсэн хуулийг таниулан сурталчлах, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг нарийвчлан судлах, олон нийтэд түгээх үүднээс энэхүү судалгааны төслийг дараах таван үе шат болон найман дэд хэсэгтэй хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дүн шинжилгээ
2. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэхээр батлах хууль тогтоомжийн явц, төлөвт холбогдох судалгаа (Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн цахим хуудас дах дашбоард мэдээллийг мөн үзнэ үү)
3. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу шинээр байгуулагдсан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн
 - 3.1. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу шинээр байгуулагдсан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийн талаарх харьцуулсан судалгаа
 - 3.2. Монгол Улсын Засгийн газруудын харьцуулсан судалгаа /2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс өмнөх ба дараа үе/
 - 3.3. Монгол Улсын Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрх /2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс өмнөх ба дараа үеийн харьцуулсан судалгаа/
4. 2019 онд оруулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэн батлах үйл явцын дүн шинжилгээ
5. 2022 онд Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт болон нэмэлт судалгаа, мэдээлэл (дашбоардын 2022 он хэсэгт 2022 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийг судалж байршуулав)
 - 5.1. 2022 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийн товч үе шат
 - 5.2. 2022 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн чиглэл цуврал
 - 5.3. 2022 оны Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой олон нийтийн байр суурь
 - 5.4. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хязгаарлалт, хууль батлах үе шат, дэлгэрэнгүй тайлбар

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГАА-1. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД 2019 ОНД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Энэ судалгаагаар 2019 онд Үндсэн хуульд оруулсан 19 зүйлийн 36 заалттай холбогдох нэмэлт, өөрчлөлт тус бүрийн 1992 онд анх батлагдсан эхийн агуулга, үзэл баримтлалыг тодруулж, тус нэмэлт, өөрчлөлтийн агуулгатай харьцуулалт хийх, тухайн нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан, хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг тодорхойлж гадаад орнуудын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлахыг зорьсон. Тус хэсэг судалгааг 2021 оны арваннэгдүгээр сараас эхлүүлж, 2022 оны хоёрдугаар сард дуусгав.

СУДАЛГАА-2. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД 2019 ОНД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭХЭЭР БАТЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЯВЦ, ТӨЛӨВТ ХОЛБОГДОХ СУДАЛГАА

Үндсэн хуулийн зүйл заалт нь өөр бусад хууль, эрх зүйн баримт бичгээр дамжин хэрэгждэг тул түүнд нийцүүлэн батлах хууль тогтоомжийн судалгаа Үндсэн хуулийн хэрэгжилтийг тандах гол асуудал мөн. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан УИХ-аас 2020 оны нэгдүгээр сарын 9-нд баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсан. Үүнтэй холбоотойгоор ямар хууль, эрх зүйн актууд шинээр батлагдаж, нэмэлт, өөрчлөлт орж байгаа талаарх үйл явцын төлөвийг судалсан. Энэхүү судалгаанд үндэслэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн гарч буй хууль, эрх зүйн баримт бичгийн талаарх дашбоардыг бэлтгэн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн харьяа Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн цахим хуудсанд байршуулсан болно. Тухайн дашбоардыг бэлтгэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж өөрчлөгдөх хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хянаж, тухайн хууль тус бүрээр аль шатанд хэрэгжиж буйг хянасан болно. Тус хэсэг судалгааг 2021 оны арваннэгдүгээр сард эхлүүлж, 2022 оны гуравдугаар сард дуусгав.


Үе шатыг тодорхойлохдоо Хууль тогтоомжийн тухай хуулийг ашиглаж дараах байдлаар жагсаав. Үүнд:

- Статус тодорхойгүй
- Боловсруулж буй
- Төсөл өргөн баригдсан
- Хэлэлцэх эсэхийг шийдвэрлэсэн
- Ажлын хэсэг байгуулагдсан
- Анхны хэлэлцүүлэгт орсон
- Эцсийн хэлэлцүүлэгт орсон
- Батлагдсан

Мэдээлэл: "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хязгаарлалт" судалгааны тайланг эндээс үзнэ үү.

Статус тодорхойгүй	Боловсруулж буй	Төсөл өргөн баригдсан	Хэлэлцэх эсэхийг шийдвэрлэсэн	Ажлын хэсэг байгуулагдсан	Анхны хэлэлцүүлэгт орсон	Эцсийн хэлэлцүүлэгт орсон	Батлагдсан
0%	20%	30%	40%	50%	60%	80%	100%

I бүлэг | Монгол Улсын бүрэн эрхт байдал



II бүлэг | Хүний эрх, эрх чөлөө



III бүлэг | Монгол Улсын төрийн байгуулал



Зураг 1: 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд холбогдох судалгааны ажлын дашибард, <https://cli.num.edu.mn/>

СУДАЛГАА-3. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД 2019 ОНД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ДАГУУ ШИНЭЭР БАЙГУУЛАГДСАН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНД ХОЛБОГДОХ СУДАЛГАА

“Монгол Улсын 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг судлах судалгааны төсөл”-ийн ажлын гуравдах хэсэгт дараах дэд судалгаануудыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

Нэг: Монгол Улсын Засгийн газрыг эмхлэн байгуулах эрх зүйн орчны судалгаа

1.1. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу шинээр байгуулагдсан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийн талаарх харьцуулсан судалгаа

- 1.2. Монгол Улсын Засгийн газруудын харьцуулсан судалгаа /2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс өмнөх ба дараа үе/
- 1.3. Монгол Улсын Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрх /2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс өмнөх ба дараа үеийн харьцуулсан судалгаа/

Монгол Улсын Үндсэн Хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг судлах оюутны судалгааны төсөл (2021-2022)

Нийтэлсэн огноо: 2022.10.04

Түүхэндээ Монгол Улс дөрвөн удаа Үндсэн хуулиа баталж байсны дөрөв дэх нь буюу одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ардчилсан, шинэ тодотголтой Үндсэн хууль нь 1992 онд батлагдаж байв. Үндсэн хууль нь нийгмийн амьдралын бүхий л хүрээний суурь харилцааг зохицуулдаг улс төр, эрх зүйн баримт бичиг гэдэг утгаараа тогтвортой үйлчлэх шинжийг агуулж байх учиртай ч нийгмийн хөгжил...

[Цааш унших](#)

1. [Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн дүн шинжилгээ](#)
2. [Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэхээр батлах хууль тогтоомжийн явц, төлөв](#)
3. [Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу шинээр байгуулагдсан засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн](#)
4. [2019 онд оруулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэн батлах үйл явцын дүн шинжилгээ](#)

Зураг 3: Судалгааны жагсаалтын гурав дах хэсэг "Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу байгуулагдсан засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, <https://cli.num.edu.mn/>

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн нэгээхэн зорилго нь гүйцэтгэх эрх мэдлийг сайжруулах, гүйцэтгэх эрх мэдэл болон хууль тогтоох эрх мэдлийн хяналт тэнцлийг сайжруулахад чиглэсэн байв. Энэхүү гурван дэд судалгаагаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахын өмнөх болон дараах үеийн Засгийн газрыг эмхлэн байгуулах асуудал, эрх зүйн орчин, үйл явц болон Ерөнхий сайдын бүрэн эрх, чиг үүргийн талаар харьцуулан судлахыг зорьсон. Тус хэсэг судалгааг 2021 оны арваннэгдүгээр сард эхлүүлж, 2022 оны гуравдугаар сард дуусгав.

Хоёр: Гуравдугаар судалгааны хоёр дахь дэд хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн талаарх гадаадын эрдэмтдийн байр суурийг судаллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар дотоодын болон гадаадын эрдэмтэн, судлаачдын байр суурийг тодорхойлохын тулд тэдний бичсэн, нийтэлсэн судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл зэргийг хэвлэмэл болон цахим материалаас түүвэрлэн хүргэхийг зорив.

СУДАЛГАА-4. 2019 ОНД ОРУУЛСАН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ ҮЙЛ ЯВЦЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ (TIMELINE)

Одоогоос 30 жилийн тэртээ Улсын Бага Хурлаас өргөн барьсан Үндсэн хуулийн төслийг Ардын Их Хурлаар эцэслэн 70 гаруй хоног хэлэлцэн баталсан. Энэхүү хурлын тэмдэглэлүүд нь 1992 оны Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалыг тодорхойлох чухал баримт болдог төдийгүй Үндсэн хуулийн судалгааны суурь мэдээллийн сан (database) юм. УИХ-ын нэр бүхий 62 гишүүн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах төслийг УИХ-д 2019 оны зургадгаар сарын 6-нд өргөн мэдүүлснээс эхлэн 2019 оны арваннэгдүгээр сарын 14-ний өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг эцэслэн батлах хүртэлх үйл явцыг бид цаг хугацааны дарааллаар, тухайн нэмэлт, өөрчлөлтүүдийн хүрээ, агуулгын өөрчлөлтүүдийг тусган харьцуулан судлав. Тус хэсэг судалгааг 2022 оны гуравдугаар сард эхлүүлж, 2022 оны зургадгаар сард дуусгав.

СУДАЛГАА-5. 2022 ОНД ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ БОЛОН НЭМЭЛТ СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ

(Дашбоардын 2022 он хэсэгт 2022 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийг судалж байршуулав.) Судалгааны ажлын энэ хэсэгт дараах дэд судалгаануудыг хийж гүйцэтгэв. Тус хэсэг судалгааг 2022 оны зургадгаар сард эхлүүлж, 2022 оны аравдугаар сард дуусгав.


Үүнд:

- 5.1. 2022 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийн товч үе шат
- 5.2. 2022 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн чиглэл цуврал
- 5.3. 2022 оны Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой олон нийтийн байр суурь
- 5.4. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хязгаарлалт, хууль батлах үе шат, дэлгэрэнгүй тайлбар

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн 19¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2028 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдөхөөр заасан. Үүнээс бусад 35 зүйл нь дагаж мөрдөгдөж эхлээд даруй хоёр гаруй жил болж байна. Энэхүү нэмэлт, өөрчлөлтүүд нь улс төрийн хүчнүүд, эрдэмтэн судлаачид, олон түмний зүгээс зарим нэг шүүмжлэл хүлээх болсон. Үүнтэй холбоотой Үндсэн хуульд ахин нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүссэн тухай асуудал хөндөгдөж, 2022 оны тавдугаар сарын 12-нд Т.Доржханд нарын гишүүд УИХ-ын даргад “Сонгуулийн тогтолцоо болон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн” талаар санал, шаардлага хүргүүлэв. Үүнийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар иргэдээс ирүүлсэн санал, улс төрийн намуудын “Тунхаг бичиг” гэж нэрлэх болсон. Энэ үйл явдалтай холбоотой Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг судлах ажлын хэсэг байгуулж, иргэдийн санаа бодлыг тандан судлах ажиллагаа хийгдсэн бөгөөд ахин нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал хуулийн агуулга, хүрээ улс төрийн орчинд хэлэлцэгдэж байна. Мөнхүү 2019 онд оруулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдох Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүд гарч УИХ ээлжит бус чуулганаараа тухайн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Энэхүү үүссэн нөхцөл байдлаас улбаалан судалгааны баг дээрх үйл явц, түүний талаарх улс төрчид, иргэд, судлаачдын байр суурь, УИХ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа зэргийг тоймлон судлав.

Судалгааны ажлын дэлгэрэнгүйг Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн цахим хуудсанд дараах байдлаар байршуулав.

Үүнээс гадна Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжит хууль тогтоомжийг судалж, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээ, хязгаар, хууль батлах үе шат, түүний дэлгэрэнгүй тайлбарыг бэлтгэн хүргэлээ.



Зураг 4: 2022 оны Үндсэн хуулийн өөрчлөлт, <https://cli.num.edu.mn/>

НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТ:

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн Хууль зүйн сургууль, ШУС-ийн Улс төрийн тэнхимтэй хамтран хэрэгжүүлсэн “Монгол Улсын 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг судлах судалгааны төсөл”-ийг МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш О.Алтантуяа, МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш Д.Бадамдаш нарын удирдлага, зөвлөгөө дор улс төр, хуулийн чиглэлээр суралцаж буй нийт 10 оюутны бүрэлдэхүүнтэйгээр судалгааны ажлыг гүйцэтгэж, (нийт 5 багц 8 дэд хэсэг бүхий судалгаа) Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн цахим хуудсанд эрдэмтэн судлаачид, оюутан залуус, олон нийтийн хүртээл болгон байршууллаа.

Энэхүү судалгааны ажил нь 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд холбогдох 19 зүйлийн 36 заалттай холбогдох нэмэлт, өөрчлөлт тус бүрийн 1992 онд анх батлагдсан эхийн агуулга, үзэл баримтлалыг тодруулж, тус нэмэлт, өөрчлөлтийн агуулгатай харьцуулалт хийх, тухайн нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан, хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг тодорхойлж гадаад орнуудын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалсан. Мөн 2022 оны Үндсэн хуулийн цэцийн 1, 2 дугаар шийдвэр, Улс төрийн намуудын зөвшилцсөн “Тунхаг бичиг”, Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаарх олон нийт, судлаачдын байр суурь, 2022 оны Үндсэн хуулийн өөрчлөлт, түүнийг даган өөрчилсөн хууль тогтоомжууд зэргийг багтаасан цогц судалгаа болно.

НЭМЭЛТ ХЭСЭГ:

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд шууд үнэлэлт, дүгнэлт өгөх нь хүндрэлтэй боловч энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр 2000 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн шүүмжлэлтэй асуудлуудыг зохих хэмжээнд засах оролдлого хийсэн, төрийн эрх мэдлийн тогтолцоо, тэдгээрийн хяналт тэнцлийг хангахад чиглэсэн дорвитой үр бий болгосон гэж үзэж байна. Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт, өөрчлөлт нь 1999 (2000) оны нэмэлт, өөрчлөлттэй харьцуулахад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын тухай хууль (2010 онд батлагдсан)-ийн дагуу хэлэлцэгдэж батлагдсанаараа давуу талтай. Үндсэн хуулийн дөрвөн бүлэгт хамаарах 19 зүйлийн 36 заалт бүхий нэмэлт, өөрчлөлтийн 29 заалт нь Үндсэн хуулийн 30 дугаар бүлэг буюу “Монгол Улсын Төрийн байгуулал” хэсэгт хамаарч байна. Үүнээс үзвэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл санаачлагчид болон хууль тогтоогчид төрийн эрх мэдлийн тогтолцоо, чиг үүрэг, хоорондох харилцаанд түлхүү анхаарал хандуулсан нь харагдаж байна.

Нийгмийн хөгжил, олон нийтийн хэрэгцээ шаардлагад үндэслэн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулах үйл явцад Үндсэн хуулийг дээдлэн сахих, түүний тогтвортой байдлыг хамгаалах, ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах, бодитой, ил тод байх зарчмыг ягштал баримтлах нь Үндсэн хуульд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхээс гадна аливаа улс төрийн бүлэглэл, нам, эвслийн явцуу ашиг сонирхлоос ангид байх боломж бүрдүүлэх болно. Мөн энэхүү судалгаа нь цаашид Үндсэн хууль, түүнтэй холбогдон гарах бусад эрх зүйн баримт бичгийг судлах судалгаанд нэгэн эх сурвалж болно хэмээн найдаж байна.